



КРЕДИТ
ББСБ



2016

ЖИЛИЙН ТАЙЛАН

解



Stronger Together.





Алсын хараа

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.



Эрхэм зорилго

Бид Монгол улсад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.



Үнэт зүйлс

- Сэтгэл ханамжтай ажиллагсад
- Харилцагч төвтэй, шинэлэг үйлчилгээ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа
- Нийгмийн хариуцлага
- Тогтвортой өндөр өгөөж

АГУУЛГА

Гүйцэтгэх Захирлын илгээлт	6
Голлох тоон үзүүлэлтүүд	8
2016 оны онцлох үйл явдал	9
Компанийн ерөнхий мэдээлэл	10
Компанийн засаглал	11
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	12
Төлөөлөн удирдах зөвлөл	13
Компанийн бүтэц	14
Нийгмийн хариуцлага	16
Бүтээгдэхүүн үйлчилгээ	17
Харилцагчид	22
Санхүүгийн дүн шинжилгээ	24
Зээлийн мэдээлэл	26
Эдийн засгийн орчин	28
ББСБ-ын зах зээл	31
Аудитын тайлан	32
Хамтран ажилладаг компаниуд	38

Эрхэм хүндэт ТУЗ-ийн гишүүд, хөрөнгө оруулагчид та бүгдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Хэдийгээр 2016 оны эдийн засаг, нийгмийн байдал сайнгүй байсан ч манай компанийн хувьд нийт хөрөнгө 22 хувь, эзэмшигчдийн өмч 74 хувь, зээлийн багц 36 хувиар тус тус өсч татварын дараах цэвэр ашиг 402 сая төгрөг буюу 19.5 хувийн дундаж өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан жил болон өнгөрлөө. Бид нийт 5.5 тэрбум төгрөгийн зээлийг 379 удаагийн олголтоор хийж нийт 382 харилцагчидтай болон ажиллалаа. Үүнээс 226 сая төгрөгийн зээлийг хөдөө орон нутгийн алслагдсан сумдад аж төрдөг 192 иргэнд хөдөөгийн хадгаламж зээлийн хоршоодоор дамжуулан олгосон байна. Улс орны зах зээлийн байдал, салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад чамлахааргүй амжилттай жил болон өнгөрлөө хэмээн дүгнэж байна.

Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш компанийн засаглал, ил тод байдал, нийгмийн хариуцлагын хувьд зах зээл дээр тэргүүлэгч байхыг эрмэлзэн ажиллаж ирсэн билээ. Тайлант хугацаанд бид нийт 7 удаагийн ТУЗ-ийн хурлыг зохион байгуулсан бөгөөд ТУЗ-ийн хороодын хурал болон дотоод аудитын ажлыг идэвхжүүлэн, тогтворжууллаа. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Дэлхийн эдийн засгийн форумын залуу манлайлагчдын нэг В.Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр урин ажиллуулж эхэлснээр манай ТУЗ 2 хараат бус, нийт 7 гишүүнтэйгээр ажиллах боллоо.

Мөн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд бид олон ажлуудыг хийж амжуулсан байна. Товч дурдвал Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо (МББСБХ)-ноос санаачилсан “1,000 цүнх” аянд бусад Банк Бус Санхүүгийн Байгууллага (ББСБ)-уудын хамт нэгдэн, амжилттай зохион байгуулсан билээ. Энэхүү арга хэмжээнд бид 1,000 гаруй

амьжиргааны түвшнөөс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд цүнх болон иж бүрэн хичээлийн хэрэгслийг бэлэглэсэн билээ. 2016 оны хувьд манай спортын баг тамирчид өндөр амжилт гаргасан жил болж өндөрлөлөө. Компанийн бахархал болсон хүндийн өргөлтийн тамирчин Э.Содномпилжээ гайхалтай амжилт үзүүлж Паралимпаас хүрэл медаль хүртэж дэлхийн хэмжээний тамирчин гэдгээ баталж чадлаа.

2016 онд манай компани хувь нийлүүлсэн хөрөнгөө төлөвлөж байсныхаа дагуу 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл (Ард Холдингс) дангаараа шинээр гаргасан хувьцааг худалдан авч 80.7 хувийг эзэмших боллоо. Түүнчлэн манай хувьцаа эзэмшигч Н.Эрдэмбаяр өөрийн эзэмшлийн хувьцаагаа Ард Холдингс-д бүхэлд нь худалдсанаар нийт компанийн 80.7 хувийг дангаараа эзэмших боллоо. Энэхүү арилжааг хийхдээ хувьцааны үнэлгээг бүртгэлийн үнийг 1.8 дахин үржүүлсэн үнээр хийсэн гэдгийг цохон тэмдэглэе.

Компанийн Алсын хараанд дурдсаны дагуу бид ямагт зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, харилцагчидтайгаа илүү ойртон ажиллахыг зорин ажилладаг билээ. 2016 онд манай багийн шаргуу хөдөлмөрийн үр дүнд Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)-тай хамтарсан кредит картаа гаргах ажлаа эцэслэж, зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд харилцагчиддаа цахимаар картаа захиалан авах боломжийг олгож www.ardcard.mn хуудсыг нээлээ. Ингэснээр бид ББСБ-ын салбартаа олон нийтэд зориулсан кредит карт гаргасан анхны байгууллага болсон бөгөөд харилцагчдынхаа талархалыг хүлээн ажиллаж чадсан юм.

Хэдийгээр бид зах зээлийн амаргүй нөхцөл ажиллаж байгаа боловч манай компанийн ТУЗ болон удирдлагын баг оновчтой

бодлого барин уйгагүй ажилласаны үр дүнд эрсдэлээ зөв удирдан хувьцаа эзэмшигчиддээ тогтвортой өгөөж бий болгон ажиллалаа.

Бидний хувьд 2017 онд эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сэргэж, цаашид тогтвортойгоор өсөн сайжрах нөхцөл бололцоо бүрэлдэж байгаа хэмээн харж байна. Иймд манай компани 2017 онд урд өмнөх жилүүдээс илүү өндөр амжилт гарган ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд ойрын ирээдүйд бүх төрлийн банкны үйлчилгээг Монгол улсын ард иргэдэд хүргэдэг болох зорилготой байна.

Хүндэтгэсэн,




Ч. Ганзориг
Гүйцэтгэх Захирал



Нийт хөрөнгө


+ 22.3%

(мянган төгрөгөөр)




Зээлийн багц

+ 36.1%




Цэвэр ашиг

- 2.2%




Зээл олголтын хэмжээ

+ 0.3%




Өөрийн хөрөнгийн өгөөж

- 5.2%



Зээлийн багц/нийт хөрөнгө

+ 8.6%




Үйл ажиллагааны зардал/дундаж зээлийн багц

- 2.2%



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

- 14.5%



- ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Дэлхийн эдийн засгийн форумын залуу манлайлагчдын нэг В.Ганзориг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж эхэллээ.
- Компанийн 2015 оны жилийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэж хэвлүүлсэн.
- Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг нь МББСБХ-ны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж эхлэв.
- Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны шинэ журмын дагуу Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх төрөлд хамрагдах ББСБ боллоо.
- “Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулга уулзалтыг Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран зохион байгуулж үндэсний хөрөнгө оруулагчдын хөдөлгөөнийг эхлүүлэв.
- Хөрөнгө оруулагчдад болон бусад оролцогч нарт зориулан бичил санхүүгийн зах зээл болон байгууллагуудын тайлан мэдээллүүдийг нэгтгэн боловсруулдаг MIXMarket-д өөрсдийн санхүүгийн мэдээллээ нээлттэй тавьж эхэлсэн.
- Хөдөө орон нутгийн иргэдийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоо (ХБСХДХ)-той хамтран чуулга уулзалт зохион байгууллаа.
- Хүний нөөцөө нэмэгдүүлж, удирдлагын багтаа Зээл эрхэлсэн захирал, Маркетингийн менежер авлаа.
- Лизингийн зээл буюу худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлэн, 10 гаруй бэлтгэн нийлүүлэгчтэй ажиллаж эхэллээ.
- МББСБХ-оос санаачилсан “1,000 цүнх” аянг хамтдаа амжилттай зохион байгуулж Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургуулийн 30 гаруй хүүхдүүдэд иж бүрэн хичээлийн хэрэгсэл бэлэглэлээ.
- Албани улсад болсон “Бичил Санхүүгийн Төв”-ийн 19 дэх уулзалтанд Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг амжилттай оролцож, компанийн танилцуулгыг хийлээ.
- Ард кредит картаа гаргахаар Худалдаа Хөгжлийн банктэй хамтран ажиллах гэрээгээ байгууллаа.
- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 80.7 хувийг эзэмших боллоо.
- Хувь нийлүүлсэн хөрөнгөө 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн СЗХ-ны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллалаа.
- Хувьцаа эзэмшигч Н.Эрдэмбаяр өөрийн эзэмшлийн 12.7 хувийн хувьцаагаа Ард Санхүүгийн Нэгдэлд бүхэлд нь худалдан гарах арилжааг амжилттай хийлээ.
- 2016 оны турш ажилласаны үр дүнд бид зах зээл дээр Ард кредит картаа амжилттай нэвтрүүлээ. Түүнчлэн харилцагчиддаа цахим хуудсаар дамжуулан картаа захиалан авах боломжийг олгож www.ardcard.mn хуудсыг нээлээ.

Ард Кредит ББСБ ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдан, бичил болон жижиг зээлийн чиглэлээр мэргэшин үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэлийн хөрөнгө оруулалттай үндэсний компани юм. Бидний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан бичил болон жижиг зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхэд оршдог билээ.

Бид өнөөдрийн байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөртэйгөөр дараах санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

- Зээлийн үйл ажиллагаа
- Валютын арилжаа
- Итгэлцлийн үйлчилгээ
- Зээлийн карт гаргах

2011	2013	2014	2015
Ард Кредит нь 2011 онд Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдаж байв.	Шинэ хөрөнгө оруулалт хийгдэж, шинэ баг бүрэлдэхүүнтэйгээр зах зээл дээр манлайлагч байгууллага болох зорилго тавин ажиллаж эхлэв. Эхний хөрөнгө оруулалт амжилттай болсон бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэлийн шууд хөрөнгө оруулалттай компани болон компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дахин өөрчлөлт оров. (ХБСХДХ) хамтарч хөдөө орон нутгийн иргэдэд бичил зээл олгож эхлэв.	Компанийн лого болон брэндийг шинэчлэн хөгжүүлэв. СЗХ-ны зөвшөөрлөөр анхны хаалттай өрийн бичгээ амжилттай гаргаж нийт 550 сая төгрөгийн санхүүжилт босгов. Хувьцаа эзэмшигчиддээ анхны ноогдол ашгийг хуваарилсан. Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлөө авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэв. Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан (БСХС)-тай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд Монгол улсын амьжиргааны түвшинөөс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.	Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Ард Санхүүгийн Нэгдэл компанийн 58 хувийг эзэмших болсон. БСХС-гаас 500 сая төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны түвшинөөс доогуур орлоготой 135 айл өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээл олгов. Боловсролыг дэмжих, оюутан залуусыг тогтвортой суралцах боломжийг олгох үүднээс Техник Технологийн Дээд Сургуультай хамтран сургалтын төлбөрийн зээлийг олгож эхэлсэн. Зээлийн өргөдлийг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсон. МББСБХ-ны Оны Шилдэг Нийгмийн Хариуцлага Хэрэгжүүлэгч Байгууллага болсон.

2016 онд бид нийт 7 удаа ТУЗ-ийн хурлыг зохион байгуулсан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг болон дотоод аудитын ажлыг идэвхжүүлэн ажиллалаа. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Дэлхийн Эдийн Засгийн Форумын Залуу Манлайлагч-дын нэг В.Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр урин ажиллуулж эхэлснээр манай ТУЗ 2 хараат бус, нийт 7 гишүүнтэйгээр ажиллах боллоо. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг батлан, олгож эхлэн гишүүдийн идэвх оролцоог өндөр түвшинд хадгалж ажиллалаа.

Бид СЗХ-ны шинээр батлагдсан журмын дагуу Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх ББСБ болсон бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөө 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай болсон билээ. Төлөвлөж байсны дагуу 1-р улиралд багтаж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх байсан боловч шинэ он гарахын өмнөхөн 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл дангаараа шинээр гаргасан хувьцааг худалдан авсан юм.

Үүний дараа дахин хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон нь Н.Эрдэмбаяр өөрийн эзэмшлийн 12.7 хувийн хувьцаагаа Ард Санхүүгийн Нэгдэлд бүхэлд нь худалдан гарах арилжааг амжилттай хийсэн явдал байв. Үүний үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл нийт компанийн 80.7 хувийг эзэмших боллоо. Хувьцааны үнэлгээг тооцохдоо 2016 оны 3-р улирлын бүртгэлийн үнийг 1.8 дахин үржүүлсэн үнээр хийсэн билээ.





В. Баяржаргал

6.6%

С. Гэрэлтуяа

12.7%

Ард Санхүүгийн Нэгдэл

80.7%





Ч.Ганхуяг
Гүйцэтгэх захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



С.Гэрэлтуяа
Гүйцэтгэх захирал
Мон Интернэшнл ХХК



В.Баяржаргал
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
ИнтерГрупп ХХК



Б.Ганбат
Гүйцэтгэх захирал
Техник Технологийн Дээд Сургууль



В.Ганзориг
ТУЗ-ийн дарга
Бат Солюшн Партнерс ХХК



Н.Эрдэмбаяр
Гүйцэтгэх захирал
Заг ХХК



Ч.Ганзориг
Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ ХХК

Компанийн дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдын хурал юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аас компанийн сайн засаглалтай ТУЗ-ийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж ирсэн. ТУЗ нь компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдлийг зохистой түвшинд байлгах, компанийн стратеги бодлогыг тодорхойлон удирдан чиглүүлэх, хянах үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.





Марал

Манай компани нь үйл ажиллагаагаа илүү бүтээмжтэй байдлаар явуулах зорилгоор толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдлээс хууль, дотоод аудит, мэдээлэл технологи, программ хангамж, харуул хамгаалалт, аюулгүй байдал зэрэг үйлчилгээг авч, хамтран ажиллах гэрээний хүрээнд ажилладаг билээ. Ингэснээр бид үндсэн үйл ажиллагаан дээрээ илүү төвлөрч, жижиг бүтцээр бүтээмжтэй ажиллах бололцоотой болдог юм.

Тайлант онд нийт 10 үндсэн ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд бидний хувьд ажиллагсад байгууллагаараа бахархадаг, байгууллагын ирээдүйг тодорхойлогч, чадварлаг, манлайлалагч, сэтггэл ханамжтай баг хамт олныг бүрдүүлэх, хүний нөөцийн үр чадварыг нэмэгдүүлэн сайжруулахаар зорин ажиллаж байна. Бид 2017 онд ажиллагсдын ажлын гүйцэтгэлийн бүтээмж ба үр дүнд үндэслэн сар бүр урамшуулал авахаар зээлийн ажиллагсдын урамшууллын шинэ системийг туршилтын шатнаас байгууллагын системийн хэмжээнд боловсронгуй болохоор төлөвлөөд байгаа билээ.



ББСБХ-ноос санаачилсан “1,000 цүнх” аянг хамтдаа амжилттай зохион байгууллаа.



Доктор Тун ХХК-тай хамтарч сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан өндөр чанартай сонсголын аппаратыг хөнгөлттэй нөхцөлтэй зээлээр олгож эхэлсэн.



Компанийн ажиллагсад Сирийн хүүхдүүдэд туслах “Хүмүүнлэг Үндэстэн” аянд оролцсон.



Бидний ивээн тэтгэж ирсэн хүндийг өргөлтийн тамирчин Э.Содномпилжээ Паралимпийн хүрэл медальтан боллоо.



“Дуулиан 2020” хүүхэд багачуудын хөл бөмбөгийн тэмцээнийг 2014 оноос хойш ивээн тэтгэж байна.



Мотокроссын улсын аварга П.Мөрөнг 2014 оноос хойш ивээн тэтгэж ажиллалаа.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургуулийн хүүхдүүдэд хандив өгөх үйл ажиллагаанд Ард Санхүүгийн Нэгдлийн компаниудтай хамтран оролцлоо.



ХБСХДХ-ны гишүүдээр дамжуулан нийт 192 хөдөө орон нутгийн иргэдэд хүрэн ажилласан байна.

Ард Кредит нь СЗХ-ны шинэ журмаар тавигдсан шаардлагын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий цөөн ББСБ-ын нэг болж үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд бид Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлийн 7.1.1 - 7.1.11 дэх бүхий л үйл ажиллагааг төрөлжүүлэн болон хавсран эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Бид одоогоор дараах төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч нартаа хүргэж байна. Үүнд:

- **Бизнесийн зээл**

- Бичил бизнесийн зээл
- Жижиг дунд бизнесийн зээл
- Хоршоо хөгжил зээл
- Төслийн зээл

- **Хэрэглээний зээл**

- Өрхийн зээл
- Цалингийн зээл
- Итгэлцэл барьцаалсан зээл
- Лизингийн зээл
- Кредит карт

- **Шуурхай зээл**

- **Бусад үйлчилгээ**

- Итгэлцлийн үйлчилгээ
- Гадаад валютын арилжаа



Ард кредит карт




Бид 2016 оны IV улирлаас бизнесийн болон цалингийн тогтмол орлоготой иргэдэд зориулан тэдний богино хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой, зээлийн эрхтэй кредит картыг “ко-бренд” хэлбэрээр ХХБ -тай хамтран нэвтрүүлснээр олон нийтэд зориулсан кредит карт гаргасан анхны ББСБ болсон билээ. Мөн бид харилцагчиддаа хурдан шуурхай, чирэгдэл багатай үйлчилгээ үзүүлэх үүднээс цахимаар кредит картаа захиалан авах боломжийг бүрдүүлж www.ardcard.mn хуудсыг нээсэн билээ.

Зээлийн дээд хэмжээ	10,000,000₮
Зээлийн доод хэмжээ	500,000₮
Жилийн хураамж	30,000₮
Хүчинтэй хугацаа	2 years
Зээлийн эргэн төлөх доод хэмжээ	10%
Хүү	2.6% - 3%



Хоршоо Хөгжлийн Зээл (Бөөний зээл)



Бид хөдөө орон нутгийн алслагдсан иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс ХБСХДХ -той 2013 оноос эхлэн хамтран ажилласан бөгөөд тус холбоо нь нийт гишүүн 57 хадгаламж зээлийн хоршоотой билээ. Тайлант онд бид нийт 9 хоршооны 192 гишүүдэд 226 сая төгрөгийн санхүүжилтийг олгож гишүүдийн аж амьдралд дэмжлэг үзүүлээд зогсохгүй орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж ажиллалаа.

Итгэлцэл

Ард Кредит нь 2014 оны 4 дугаар сард Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд харилцагчдадаа өндөр өгөөж бүхий санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгож ирсэн билээ. Тайлант онд бид нийт 1.5 тэрбум төгрөгийн итгэлцлийн хөрөнгө татан төвлөрүүлж ажиллалаа.

Mon éclair

since 2016

Нэйчэ сайэнс ХХК нь 2016 оны 02 дугаар сарын 18-нд анх уул уурхайн зураг төсөл, хайгуул, далд уурхайн сургалт, зөвлөгөө үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн хүнс болон байгалийн гаралтай бүтээгдэхүүн гаргаж авах үйлдвэрлэл нэвтрүүлэх зорилго тавин Мон эклэр бэйкери кофе шопийг амжилттай нээж үйл ажиллагааны гараагаа анх тавьсан байна. Одоогийн байдлаар Мон Эклэр компани нь нийт үндсэн 6 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 15 төрлийн эклэрийг олон улсын стандартын дагуу хэлбэр хэмжээ, өнгө үзэмж, амт чанартайгаар өдөр бүр хэрэглэгчдэд хүргэж байна.

2016 оны сард үйл ажиллагаагаа өргөжүүлэн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Ард Кредит ББСБ-ын жижиг дунд бизнесийг дэмжих зээлийг авснаар богино хугацаанд санахүүгийн хэрэгцээгээ ханган ажиллах боломжтой болсон билээ.





2012 оноос “Ganaa Sansa” нэртэй бие даасан үйлдвэрээ байгуулж Солонгосдоо томоохон гэгдэх брэндүүдийн захиалга авч гүйцэтгэгч үйлдвэр болон өргөжиж чадсан. Сүүлийн жилүүдэд Louis Quatorze, MCM, Hazzys ба Bean Pole гэх мэт томоохон брэндүүдийг захиалгаар хийж гүйцэтгэдэг болсон.

Үйл ажиллагаагаа өргөжүүлэн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Ард Кредит ББСБ-ын жижиг дунд бизнесийг дэмжих зээлийг авснаар богино хугацаанд санахүүгийн хэрэгцээгээ ханган ажиллах боломжтой болсон билээ.

Тайлант онд компанийн нийт хөрөнгийн хэмжээ 22 хувь өсч 5.7 тэрбум төгрөгт, нийт зээлийн багцын хэмжээ 36 хувь өсч 4.9 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Зээлийн эрсдэлийн сан 90 хувиар өсч 241 сая төгрөгт хүрсэн ба энэ нь нийт чанаргүй зээлийн 95 хувьд хүрч байгаа юм. Нийт өр төлбөрийн хувьд 13 хувиар буурч 2.4 тэрбум төгрөгт хүрсэн ба энэхүү бууралт нь бид Ард Холдингсоос авсан байсан нийт 870 сая төгрөгийн жилийн 15 хувийн хүүтэй зээлээ оны өмнө хаасантай холбоотой юм. Нийт өр төлбөрийн 90 хувийг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө эзлэж байгаа бөгөөд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 71 хувийг итгэлцлийн үйлчилгээгээр байршуулсан хөрөнгө эзлэж байна. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ 1.9 тэрбумаас 3.3 тэрбум төгрөгт хүрч 1.4 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд

энэхүү өсөлтийн 71 хувь буюу 1 тэрбум төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмсэнтэй холбоотой юм.

Орлого үр дүнгийн хувьд бид нийт 402 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд энэ нь 19.5 хувийн дундаж өөрийн хөрөнгийн өгөөжтэй тэнцэж байна. Хүүгийн орлого өмнөх оноос 8 хувиар өсч 1.4 тэрбум төгрөгт хүрсэн боловч эрсдэлийн сангийн зардал 115 хувиар нэмэгдэж 154 саяд, хүний нөөцөө нэмсэнтэй холбоотойгоор нийт үйл ажиллагааны зардал 13 хувиар өсч 548 саяд тус тус хүрсэн нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөллөө. Зээлийн эрсдэлийн хувьд нийт багцын 6.9 хувь нь 0-ээс дээш хоногоор хугацаа хэтрэн гарсан байна.



ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (мянган төгрөгөөр)	2012	2013	2014	2015	2016
Нийт хөрөнгө	560,025	1,827,144	3,388,254	4,651,476	5,692,661
Зээлийн багц	551,120	1,630,936	2,610,964	3,579,130	4,868,065
Өр төлбөр	2,522	546,337	1,807,415	2,759,773	2,399,080
Өөрийн хөрөнгө	557,503	1,280,808	1,580,839	1,891,703	3,293,581
Хүүгийн орлого	97,369	261,179	889,298	1,234,028	1,363,844
Цэвэр ашиг	37,109	123,305	300,031	410,864	401,764
Үйл ажиллагааны зардал	54,131	133,679	314,452	484,199	548,285
Зээл олголтын хэмжээ		1,692,037	4,639,163	5,488,955	5,503,224

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012	2013	2014	2015	2016
Өөрийн хөрөнгийн өгөөж	7.00%	13.00%	21.40%	24.70%	19.50%
Өр төлбөр/өөрийн хөрөнгө	0.50%	42.70%	114.30%	145.90%	72.80%
Зээлийн багц/нийт хөрөнгө	98.40%	89.30%	77.10%	76.90%	85.50%
Хугацаа хэтрэлт 0< хоног	0.00%	3.00%	8.60%	8.50%	6.90%
Эрсдэл даах чадвар	100.00%	27.50%	57.10%	51.50%	95.00%
Үйл ажиллагааны зардал/дундаж зээлийн багц	9.80%	8.20%	12.00%	13.50%	11.30%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	98.40%	26.30%	27.80%	24.20%	9.70%
Санхүүгийн тогтвортой байдал	179.90%	162.90%	152.50%	145.90%	128.60%

Эдийн засаг, бизнесийн таагүй орчинд зарим секторт зээл олголтыг хязгаарлах бодлогын барьж ажилласан хэдий ч зээлийн багцын хувьд өмнөх оноос 36 хувиар өссөн боловч идэвхтэй зээлдэгчийн тооны хувьд төслийн зээлийн санхүүжилттэй холбоотойгоор өмнөх оноос буурч, 382-т хүрсэн. Энэхүү идэвхтэй зээлдэгчийн тоо буурсан нь зээлийн дундаж хэмжээг 15.2 сая төгрөг болж өсөхөд нөлөөлж байна.


Зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 2.6 хувьд хүрч

өмнөх улирлаас 0.1 хувиар буурсан бөгөөд ББСБ-ын салбарын дундаж хүүтэй харьцуулахад хүүгийн зөрүү 1.4 хувь байгаа юм.

Зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор ТУЗ-өөс тогтоосон зээлийн эрсдэлийн хязгаар үзүүлэлтүүд болон СЗХ-ноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж ирсэн.

Зээлийн хэмжээ

(мянган төгрөгөөр)



Нийт зээлийн тоо



Дундаж зээлийн хэмжээ



Зээлдэгчдийн тоо



Нийт олгосон зээлийн үлдэгдлийн 21 хувь нь хэрэглээний зээл, 79 хувь нь бичил болон жижиг, дунд бизнесийн зээл байгаагаас үйлчилгээний салбар дэх зээлийн багцын эзлэх хувь хэмжээ өндөр үзүүлэлттэй байгаа нь бидний хөдөө орон нутгийн алслагдсан иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс ХЗХ-доор дамжуулан олгож буй бөөний зээлийн үйлчилгээтэй холбоотой юм.



Олгосон зээлийн хэмжээ

(мянган төгрөгөөр)

2016		5,505,224
2015		5,488,955
2014		4,639,163

Олгосон зээлийн тоо

2016		379
2015		603
2014		386

Эдийн засгийн нөхцөл саарч буй үед компани нь зээл олголтыг зохих түвшинд хязгаарлаж, зарим зээлийн нөхцөл, шаардлагаа чангатгаж ажилласан нь зээл олголтод тодорхой хувиар нөлөөлсөн гэж үзэж байгаа. Тайлант хугацаанд зээл олголт өмнөх оноос 0.3 хувиар өсч, 379 зээлдэгчид 5.5 тэрбум төгрөгийн зээл олголоо.

2011 онд Монгол Улс 17.4 хувь буюу дэлхийн хамгийн өндөр эдийн засгийн бодит өсөлттэй гарч байв. Гэвч энэхүү хоёр оронтой өсөлтийг хадгалж чадаагүй бөгөөд эдийн засгийн өсөлт тогтмол буурсаар ирсэн юм. 2016 онд Монгол Улсын ДНБ-ийн өсөлт 1 хувьд хүрэв. Энэ нь Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон Олон Улсын Валютын Сан зэрэг байгууллагуудаас таамагласан өсөлтөөс өндөр байгаа хэдий ч сүүлийн 7 жилийн өсөлттэй харьцуулахад хамгийн доод түвшинд хүрэв. Хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлсэн ба Рио Тинтогоос хэрэгжүүлж буй Оюу Толгойн зэс болон алтны төсөл, оны 2 дугаар хагаст Хятадын нүүрсний эрэлт нэмэгдсэнээс үүдсэн үнийн өсөлт зэргээс шалтгаалсан уул уурхайн салбарын төслүүдийн эрчимжилт ДНБ-нд нөлөөллөө.


2016 онд нэрлэсэн ДНБ 23.9 их наяд төгрөгт хүрсэн ба 2010 оны суурь үнээр тооцвол 16 их наяд төгрөг болсон байна. Мөн төсвийн алдагдал ДНБ-ий 15 хувьтай тэнцэж, 3,667.8 тэрбум төгрөгт хүрчээ. 2016 онд урсгал данс 449 сая долларын алдагдалтай, хөрөнгийн данс 92 сая долларын илүүдэлтэй, санхүүгийн данс 615 сая долларын алдагдалтай гарч, 277 сая

долларын дансны тохируулга хийснээр нийт төлбөрийн тэнцэл 18 сая долларын алдагдалтай гарсан байна.

2011 оноос 2016 онуудад гадаад өр төлбөрийн хэмжээ 152 хувиар өсч 24.3 тэрбум долларт хүрсэн бөгөөд гадаад валютын нөөц 1.3 сая долларт хүрч, 115 хувиар буюу 1.5 сая доллароор буурсан байна. Мөн энэхүү хугацаанд төгрөгийн доллартай харьцах ханш 76 хувиар унаж 1 доллар 2,482.6 төгрөгтэй тэнцлээ. 2016 онд Монголбанк 1.2 тэрбум долларын интервенц хийсэн боловч, төгрөгийн ханш 24 хувиар унасан байна. 2016 оны 12 сарын байдлаар Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 578.3 тэрбум төгрөг байна. Инфляцийн түвшин улсын хэмжээнд 1.1 хувьтай гарсан бөгөөд Улаанбаатар хотын хувьд 0.5 хувьтай байна.

2016 онд нийт гадаад худалдааны эргэлт 8,275.3 сая долларт хүрснээс экспорт 4,917.3 сая доллар, импорт 3,357.9 сая долларыг эзэлж, гадаад худалдааны тэнцэл 1,559.4 сая долларын ашигтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад 687.6 сая доллараар нэмэгдсэн байна.

ДНБ, үйлдвэрлэлийн
аргаар, оны үнээр
(сая төгрөг)




Гадаад худалдаа
(сая доллар)




Улсын төсвийн
тэнцвэржүүлсэн
орлого, зарлага,
тэнцэл, жилээр
(сая төгрөг)




Гадаад валютын улсын нөөц
(сая доллар)




Нийт гадаад өр
(сая доллар)



Зээлийн хүү, хувиар



Зээлийн өрийн үлдэгдэл, сар бүрийн эцсийн
байдлаар
(тэрбум төгрөг)



Эдийн засгийн өсөлт удааширч санхүүгийн хэрэгцээ шаардлага ихэссэнтэй холбоотойгоор тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудын тоо 2016 онд хурдацтай өссөн байна. 2016 оны байдлаар нийт ББСБ-ийн тоо 518-д хүрч өмнөх оноос мөн үетэй харьцуулахад 15.1 хувь өссөн байна.

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 787.2 тэрбум

төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар өслөө. Энэхүү өсөлт нь СЗХ-ноос 2015, 2016 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай шууд холбоотой буюу ББСБ-уудын өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар өссөн нь голчлон нөлөөлсөн байна.

Нийт ББСБ

518

Нийт Актив

787.2
тэрбум

Нийт зээлийн багц

478.2
тэрбум

Нийт өөрийн
хөрөнгө

578.5
тэрбум

Нийт хувь
нийлүүлсэн
хөрөнгө

440.5
тэрбум

Банкны салбарт эзлэх хувь
3.1%

Банкны салбарт эзлэх хувь
3.9%

Банкны салбарт эзлэх хувь
18.6%


Банкны салбарт эзлэх хувь
68.8%

Зээлийн сарын дундаж хүү

Банк **2%**

ББСБ **4%**

Зээлийн багцын чанар



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Ард кредит ББСБ” ХХК-ийн Хувь Нийлүүлэгчдэд

Аудиторын дүгнэлт

Бид “Ард кредит ББСБ” ХХК(‘компани’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2016 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт(‘СТОУС’)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёсзүйн олон улсын стандартын зөвлөл(‘НБЁЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын Ёсзүйн дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёсзүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёсзүйн шаардлагуудын дагуу хүлээх бусад ёсзүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан, аудитаар олж авсан бидний мэдлэг, өөр бусад материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юмуу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсч болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа юмуу нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн Хавсралтад харуулсан. Энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь энэхүү аудиторын тайлангийн нэг хэсэг болно.



Огноо: 2017.03.28

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	2016 он мян.төг	2015 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	1,363,844	1,234,028
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(358,441)	(290,199)
Хүүгийн цэвэр орлого	1,005,403	943,829
Шимтгэлийн орлого	37,243	50,394
Гадаад валютын арилжааны орлого/(зардал)	(1,943)	(360)
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого/(зардал)	26,724	11,004
Хүүгийн бус цэвэр орлого	62,024	61,038
Үйл ажиллагааны орлого		1,004,867
Боловсон хүчний холбогдолтой зардал	(277,745)	(228,180)
Үйл ажиллагааны бусад зардал	(250,749)	(249,852)
Үйл ажиллагааны бус бусад орлого/(зардал)	46,251	(2,025)
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, (алдагдал)	585,184	524,810
Зээлийн үнэ цэнийн бууралтын (зардал), буцаалт	(131,478)	(66,304)
Татварын өмнөх ашиг	453,706	458,506
Орлогын албан татвар	(51,942)	(47,528)
Татварын дараах цэвэр ашиг	401,764	410,978
Нэгж хувьцаанд ногдох ашиг	39	41

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2016 оны 12-р сарын 31 мян.төг	2015 оны 12-р сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	233,179	637,193
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	30,000
Санхүүгийн хөрөнгө	5,000	5,000
Харилцагчдад олгосон-цэвэр	5,056,130	3,733,138
Бусад санхүүгийн хөрөнгө	11,191	55,170
Бусад санхүүгийн бус хөрөнгө	53,021	60,826
Өмчлөх бусад хөрөнгө	97,600	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	233,817	126,144
Биет бус хөрөнгө-цэвэр	2,723	4,003
НИЙТ ХӨРӨНГӨ	5,692,661	4,651,476
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Өмч		
Дүрмийн сан	1,312,500	1,000,000
Нэмж төлөгдсөн капитал	787,500	100,000
Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	1,193,581	791,817
Өмчийн дүн	3,293,581	1,891,817
Өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	1,649,304	897,756
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	190,000	472,082
Бусад эх үүсвэр	442,400	1,351,564
Бусад санхүүгийн өр төлбөр	85,747	11,080
Бусад санхүүгийн бус өр төлбөр	31,629	27,177
Өр төлбөрийн дүн	2,399,080	2,759,080
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	5,621,661	4,651,476



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	НИЙТ мян.төг
2015 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,000,000	480,839	100,000	1,580,839
Төлсөн ногдол ашиг	-	(100,000)	-	(100,000)
Тайлант хугацааны цэвэр ашиг	-	410,978	-	410,978
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000	791,817	100,000	1,891,817
Гаргасан хувьцаа	312,500	-	-	312,500
Тайлант хугацааны цэвэр ашиг	-	401,764	-	401,764
Нэмж төлөгдсөн капитал	-	-	687,500	687,500
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,312,500	1,193,581	787,500	3,293,581

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2016 он (мян.төг)	2015 он (мян.төг)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг /(алдагдал)	453,706	458,506
<i>Тохируулга:</i>		
Элэгдэл, хорогдол	22,758	24,061
Авлагын эрсдэлийн зардал (нөхөлт)	22,624	2,266
Үндсэн хөрөнгө худалдсаны (олз) гарз	(71,280)	(3,342)
Зээлийн эрсдэлийн сангийн зардал (нөхөлт)	131,478	66,304
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний тэгшитгэл		3,096
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	559,286	550,891
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өөрчлөлт	30,000	20,000
Зээл ба урьдчилгааны өөрчлөлт	(1,420,414)	(1,034,470)
Бусад санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт	21,356	106,867

Бусад санхүүгийн бус хөрөнгийн өөрчлөлт	7,805	(39,423)
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн өөрчлөлт	(97,600)	(3,096)
Итгэлцлийн үйлчилгээний өөрчлөлт	709,591	344,709
Бусад санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт	74,667	10,038
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өөрчлөлт	1,554	3,796
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлт	(673,040)	(591,578)
	(113,754)	(40,687)
Төлсөн орлогын албан татвар	(49,044)	(45,125)
Хүүгийн орлого	(1,363,844)	(1,234,028)
Хүлээн авсан хүү	1,329,787	1,127,217
Хүүгийн зардал	358,441	290,199
Төлсөн хүү	(318,531)	(259,412)
	(43,191)	(121,149)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон /(түүнд шингэсэн) цэвэр мөнгөн гүйлгээ	(159,946)	(161,835)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(425,217)	(109,050)
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө	-	(5,000)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(425,217)	(114,050)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гаргасан хувьцаат капитал	1,000,000	-
Өрийн бичгийн эргэн төлөлт	-	(250,000)
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,954,915	1,597,350
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлт	(3,776,767)	(786,841)
Төлсөн ногдол ашиг	-	(100,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	178,148	460,509
Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(404,015)	184,624
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эхний үлдэгдэл	637,194	452,570
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эцсийн үлдэгдэл	233,179	637,194





Ердийн даатгал



Банк бус санхүүгийн
байгууллага



Хадгаламж зээлийн
хоршоо



Брокер, диллер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Хөрөнгө
оруулалтын менежмент



Тэтгэврийн сан



Шуудангийн
Цогц Шийдэл



Үл хөдлөх хөрөнгийн
түрээс



Санхүүгийн програм
хангамж



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН**

Хөрөнгө
оруулалтын сан



📍 “Ард Холдингс”-ын байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс

📄 цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

📞 (+976) 7700 3322

✉ info@ardcredit.com

🌐 www.ardcredit.com

📌 fb.com/ArdCredit